

Инно хими лаб ХХК



ИННО ХИМИ ЛАБ ХХК

МЭДЭЭЛЛИЙН НЭР:

**ЕВРОПЫН ХОЛБООНЫ
СЭРЭМЖЛҮҮЛЭГ, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ СҮЛЖЭЭНИЙ 2023
ОНЫ ТАЙЛАНГИЙН АЛБАН БУС
ОРЧУУЛГА**

Хоёрдугаар цуврал

Утас: 77051414
И-мэйл: info@innochem.mn
Вэбсайт: www.medimpex.mn
Фэйсбүүк:
Инно лаборатори
Agilent Demo Center


Мэдээллийн эх сурвалж: [2023 Annual Report - Alert and Cooperation Network](#)

ЕВРОПЫН ХОЛБООНЫ СЭРЭМЖЛҮҮЛЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ СҮЛЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТАЙЛАН

3.2. Удирдлагын тусламж ба хамтын ажиллагааны (ААС) сүлжээ

2023 онд ААС-ийн сүлжээнд тавигдсан мэдэгдэл 3166-д хүрч, 2022 оныхоос 24%-иар өсч 2021 онтой харьцуулахад бараг хоёр дахин өссөн байна. Хамгийн их мэдэгдлийг Герман (29.3%), түүний дараа нь Болгар (12.8%), Австри (7.5%) улсууд тус тус гаргажээ.

Мэдэгдлийн 60% орчим нь ЕХ-ын гишүүн улсуудад бүртгэгдсэн бараа бүтээгдэхүүн, үлдсэн нь ЕХ-оос гадуурх орнуудаас ирсэн бүтээгдэхүүнд илэрсэн зөрчлүүд байна. 2022 оны чиг хандлагыг харахад, 2023 онд ААС-д бүртгэгдсэн тохиолдлуудын дийлэнх хувь нь хоол хүнс (86.6%), дараа нь амьтад (7.3%), тэжээл (3.7%), хүнсний сав баглаа боодлын материал (2.4%)-тай холбоотой мэдэглүүд байна.



Зураг 8-д харуулснаар болон 2019 оноос хойш бүртгэгдсэн мэдэгдлүүдийг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилж харвал хамгийн их мэдэгдэл жимс, хүнсний ногоо (24%-н дээр байсан бөгөөд 2022 оныхтой харьцуулахад 72%-иар өссөн байна. 763 мэдэгдлээс 642 нь пестицидийн үлдэгдлийн мэдэгдэл байсан бөгөөд ААС-ийн тайланд хамгийн их нэмэгдэж орсон зөрчилд орж байна. Fenbutatin oxide болон acetamiprid хамгийн их давтагддаг пестицид байсан ба эхнийх нь ЕС-д зөвшөөрөгдөөгүй пестицид байсан бол сүүлчийнх нь зөвшөөрөгдсөн боловч пестицидийн үлдэгдлийн Зөвшөөрөгдөх Дэд Хэмжээ (MRL) нь хэтэрсэн байна. **Хамгийн чухал нь мэдэгдэл гаргаж буй ихэнх тохиолдлыг хил дээр дээж авч шинжилгээнд хамруулж чадсан учраас Европын зах зээлд орохыг түдгэлзүүлж буцааж чадсан байна.** Тиймээс энэхүү системийн зорилго нь бусад гишүүн орнуудад зөрчлийн талаар мэдээлэхэд оршиж байгаа юм.

Амьд амьтад 2022 оныхоос 122%-иар өсч, ААС-д (7.3%) бүртгэгдсэн мэдэгдлээрээ хоёрдугаарт орсон байна. Зөрчлийн 77% нь эрүүл мэндийн гэрчилгээ буруу, шаардлага хангаагүй эсвэл дутуу, байхгүй, эрүүл мэндийн гэрчилгээ эсвэл тодорхойлох бичиг баримт байхгүй байсантай холбоотой.


Тусгай хоолны дэглэмийн хүнс, нэмэлт бүтээгдэхүүн, баяжуулсан хүнс (7.2%)-тэй холбоотой зөрчлүүд гуравдугаар байрт оржээ. Эдгээрийн бараг тал хувь нь хаяг шошго эсвэл тайлбарууд буруу, худлаа байсантай холбоотой бөгөөд гол нь эдгээр хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүдийг ямар нэг өвчнөөс урьдчилан сэргийлдэг, эмчилдэг, эмчлэх шинж чанартай (сэтгэл гутралаас урьдчилан сэргийлэх, үрэвслийг дарах болон тураах нөлөөтэй) гэх мэтээр тайлбарладаг байна. Өөр нэг давтагддаг асуудал бол орц найрлагын хувьд тохирохгүй байсан (59) ба **хаяг шошго дээр бичсэн тэмдэглэгээ болон бүтээгдэхүүнийг шинжлэхэд илэрч буй үзүүлэлтүүдийн хооронд зөрүүтэй байх** (витамин, эрдэс бодис) эсвэл зөвшөөрөгдөөгүй шинэ хүнс эсвэл шинэ хүнсний орцуудыг хэрэглэснээс үүдэлтэй зөрчлүүд орж байна.

Үр тариа, талхны бүтээгдэхүүнүүдэд илэрч буй зөрчил дөрөвдүгээр байранд (6.3%), гол төлөв пестицид болон нэмэлт бодис илэрсэнтэй холбоотой асуудлууд (эрүүл мэндэд аюул учруулахгүй түвшинд) орсон. Түүнээс гадна, хэд хэдэн тохиолдолд орцуудын жагсаалт болон шим тэжээлийн хүснэгтийн зөрүүтэй байх, үйлдвэрлэл эсвэл хадгалалтын хугацааны он сар өдөр буруу байх гэсэн зөрчлүүд илэрч байна.

Дахин давтагддаг зөрчлийн ангилалд мах, махан бүтээгдэхүүнүүд (шувууны махнаас бусад) (5.5%) хамрагдаж байв. Үүнд ихэвчлэн буруу хаяг шошготой байх, мэдээллээсээ зөрөх (79) зөрчлүүд байна. Зохих ёсны бичиг баримт дутуу, эсвэл боловсруулалтын зохисгүй асуудал (29), мөн боловсруулалтын үеийн, баримт бичгийн эсвэл хяналтын нийтлэг зөрчил байсан ба эхнийх нь албан ёсны гэрчилгээ хангаагүй эсвэл дутагдсанаас сүүлчийнх нь эрүүл ахуйн нөхцөл муу, температурын хяналт муутай холбоотой байв.

Эцэст нь загас, загасан бүтээгдэхүүн (4.2%) нь ихэвчлэн буруу шошго, жин хэмжээтэй холбоотой мэдээлэл байхгүйтэй холбоотой. Загас, загасан бүтээгдэхүүний усны мөстэй глазур эсвэл хадгалах нөхцөлийн талаар гомдол гаргасан. Түүнээс гадна боловсруулалт болон хадгалалтын нөхцөлийг буруу хангасан хэд хэдэн тохиолдол бий болсон байна (32).

ААС-ын мэдэгдлүүдийг үл тохирлоор ангилахад:



Зураг 9-д харуулснаар хамгийн их мэдээлэгдсэн үл тохирлуудад хүнсний бүтээгдэхүүний найрлагын зөрчил (36.3%) байсан бөгөөд энэ нь пестицидын үлдэгдлийн хэмжээ MRL-ээс дээш байсан ч гэсэн үнэлгээний үр дүнд эрүүл мэндэд эрсдэлгүй гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Хоёр дахь хамгийн их бүртгэгдсэн ангилал нь хаяг шошгын мэдээлэл буруу гэсэн мэдэгдэл (32%) **байсан бөгөөд шошгон дээрх мэдээлэл нь дутуу эсвэл байхгүй (орцуудын жагсаалт, шим тэжээлийн мэдэгдэл гэх мэт) эсвэл эрүүл мэндэд хэрэгтэй гэх зөвшөөрөгдөөгүй орцуудыг хэрэглэсэн мэдэгдлүүд байв.**

Худалдааны болон тээврийн бүртгэл, эрүүл мэндийн гэрчилгээ, амьтны тодорхойлолтын бичиг баримт зэрэг олон төрлийн баримт бичгийн зөрчлүүд байсан бөгөөд жишээлбэл бичиг баримт дутмаг, буруу эсвэл байхгүй байх (12.9%) гэх мэт зөрчлийн мэдээллүүд гарсан байна. Энэ ангилалд ихэвчлэн амьтны гаралтай бүтээгдэхүүн эсвэл амьд амьтдыг багтаадаг бөгөөд тэдгээрийг тээвэрлэх, худалдахад хэд хэдэн бичиг баримт шаарддаг.

Нянгийн бохирдол, тээвэрлэлтийн үед температурын хяналт муу, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй орчинд бэлтгэгдсэн зэрэгтэй холбоотой мэдэгдлүүд нийт мэдэгдлийн 7.5%-ийг эзэлсэн байна. Бүртгэгдсэн хэргүүдийн 4.8% нь (2022 оныхоос хоёр дахин өссөн) "бусад" гэж ангилсан бөгөөд гол нь шинжилгээний аргачлал, операторуудыг баталгаажуулах, үндэсний болон Европын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар гишүүн орнууд хоорондоо нэг нэгээсээ мэдээлэл солилцох хүсэлтүүд хамрагдаж байна.

Үлдсэн мэдэгдлүүдэд гаднын биетээр бохирдох (2.8%), тохиолдлоор эсвэл байгаль орчны бохирдлууд (2.6%) орж байна. Эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй ААС-ийн аливаа мэдэгдлийг зөв үнэлж шаардлагатай бол RASFF-ийн системд шилжүүлэхийг ЕС баталгаажуулдаг.

3.3. Хуурамч ХАА-н гаралтай хүнсний сүлжээ

Хуурамч хүнстэй холбоотой мэдэгдлийн тоо нийт 758-д хүрч, гишүүн орнуудын эрх баригчид 2022 оныхтой харьцуулахад сүлжээг ашиглах тоо 26.3%-иар өссөн байна. Мэдэгдлүүдийн талаас илүү нь (414) 2023 онд дуусах ЕХ-ны тусгай зохицуулсан үйл ажиллагааны улмаас хууль бус наймаа, муур, нохойтой холбоотой байна. Энэ талаар 3.3.1 хэсэгт дэлгэрэнгүй оруулсан. Бусад бүтээгдэхүүний ангилалд хамаарах 344 мэдэгдэлтэй холбоотой судалгааг дараах хэсэгт тайлбарлаж байна.

Хуурамч сэжигтэй мэдэгдлийг хамгийн их үүсгэсэн улсуудад Бельги (18.3%), дараа нь Герман (16.5%), Франц (10.7%) гэсэн орнууд орж байна. ЕХ-ноос үүсгэсэн мэдэгдлүүд 2023 онд 3.4%-д хүрч байсан бөгөөд шүтэл үлээгчийн мэдээлэл зэрэг тодорхой, тусгай мэдээллүүдийг хуваалцсан байна.

- **Хүнсний гарал үүсэл**

Мэдээлсэн бүтээгдэхүүний ихэнх буюу 71% нь гарал үүслийн хувьд ЕХ-оос үүсэлтэй бол 24% нь ЕС-ийн бус орнуудаас импортлогдсон байна. Мэдэгдлийн багахан хувь нь (4.8%) гарал үүслийн хувьд тодорхойгүй эсвэл шалгагдаж байгаа гэсэн байна.

ЕХ-ны орнуудаас ирж буй барааны тухайд 8.2% нь Франц, Нидерландтай холбоотой байна. Сүүлчийнх нь хувьд тахиа, шувууны бүтээгдэхүүнийг дууриалгах, мах махан бүтээгдэхүүний буруу хаяг шошгожилт байсан бол хамгийн их давтагдсан асуудалд Францаас ирж буй амьд амьтдыг дагалдах хуурамч бичиг баримтын тухай олон мэдэгдэл байсан. ЕХ-ны бус орнуудаас ирж буй бүтээгдэхүүнтэй холбоотой хэргүүдийн 5.4% нь Хятад, 3.4% нь Турк гаралтай бүтээгдэхүүнүүд багтсан байна.

- **Бүтээгдэхүүний ангилал**

Зураг 10: Хуурамч хүнсний мэдэгдлүүдийг бүтээгдхүүний ангиллаар харуулбал



2023 онд хамгийн их мэдэгдэл гаргасан бүтээгдэхүүн нь мах махан бүтээгдэхүүн (шувууны шувуунаас бусад) байсан бөгөөд нийт хүнсний луйвар, хуурамч хүнсний мэдэгдлийн 13.3%-ийг эзэлсэн байна. Нийтлэг гарч буй зөрчлүүдийг ангилбал орц болон төрөл зүйлийг орлуулах, буруу, төөрөгдөлд хүргэх хаяг шошго зэрэг байв.

2022 оныхтой адил амьд амьтад (тэжээвэр амьтдыг эс тооцвол)-тай холбоотой зөрчлүүд хамгийн их бүртгэгдсэн (10.1%) байсан бөгөөд өмнөх жилүүдтэй адил ихэвчлэн адуутай холбоотой хэргүүд байсан. Адууг нууцаар оруулж ирэх эсвэл амьтны паспорт, эрүүл мэндийн гэрчилгээ зэрэг заавал дагалдах ёстой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдлуудын тоо бараг тэнцүү байна.

Хэдийгээр 2022 оны ЕХ-ны хамтарсан зөгийн балны талаарх арга хэмжээний хүрээнд дүгнэлтээ гаргасан боловч зөгийн бал болон royal jelly (цэлцэгнүүр) нь нийт гарч буй хүсэлтийн 9%-ийг бүрдүүлэн хамгийн их мэдэгдэл гарч буй эхний гурван бүтээгдэхүүний ангилалд хамаарч байна. Мэдэгдлийн гол шалтгаан нь **зөгийн балыг элсэн чихрийн сиропоор** шингэлсэн гэсэн дүгнэлтүүд байна.


2022 оныхтой харьцуулахад өөх тос (8.7%)-ны талаархи мэдэгдлүүд өссөн байна. Ихэнх нь чанарын хувьд эсвэл хаяг шошгыг буруу тэмдэглэсэн зөрчлүүд байсан **бөгөөд чанарын доод ангиллын чидун тосыг extra virgin буюу дээд ангиллын чидун тос хэмээн зарж борлуулдаг** байв.

Хоолны дэглэм, нэмэлт бүтээгдэхүүн, баяжуулсан хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой хуурамч бүтээгдэхүүний тоо (7.8%) өссөөр байна. 2022 онд бүртгэгдсэн эдгээр бүтээгдэхүүнтэй холбоотой мэдэгдлүүдийн адил ихэнх тохиолдолд зөвшөөрөгдөөгүй бодис нэмэх, эрүүл мэндийн батлагдаагүй шинж чанарыг бүтээгдэхүүнд байгаа мэтээр хэрэглэхтэй холбоотой тохиолдлууд байна.

Загас болон түүнтэй холбоотой бүтээгдэхүүн нийт мэдэгдлийн 6.9%-ийг эзэлсэн байна. 2022 оныхтой адил, эдгээр бүтээгдэхүүний луйврын сэжиг нь үнэ цэн багатай төрөл зүйлээр орлуулах эсвэл ус нэмсэн зөрчлүүд илэрч байна. Мөн шувууны мах, шувууны махан бүтээгдэхүүн (5.8%) дээр ч гэсэн ийм зөрчил бүртгэгдсэн байна. Ургамал

хамгаалах бүтээгдэхүүний ангиллын зөрчил 6.1% болж өссөн бөгөөд үүнд хууль бусаар ашиглах, худалдахад гол анхаарал хандуулж байна, Энэ талаар 3.3.2 хэсэгт хэлэлцэх болно. Сүү, сүүний бүтээгдэхүүнтэй холбоотой мэдэгдлүүд 5.5%-д хүрчээ. Кипр, Грек улсуудын тэн хагасаас илүү нь Хамгаалагдсан гарал үүсэл (PDO), Хамгаалагдсан газар зүйн заалттай бүтээгдэхүүн (PGI) болон Уламжлалт мэргэжлийн баталгаатай (TSG) гэсэн ангилалд хамаарах зөрчлүүдийн талаар мэдэгдсэн байна.

Зураг 11: Хуурамч хүнсний талаарх мэдэгдлүүдийг зөрчлийн шинжээр нь ХАА-н гаралтай хүнсний ангилал болон дэд ангиллаар нь ангилж харуулбал



Зураг 11-д харуулснаар өмнөх жилүүдэд ч гэсэн хүнсний бүтээгдэхүүний хууль бус хүнсний мэдэгдлүүдээс хамгийн ихээр бүртгэгддэг зөрчилд бүтээгдэхүүнийг өөр зүйлээр орлуулах/хуурамчаар дууриалгах (40.4%) ангилалд хамаарч байна. Энэ ангиллын тодорхойлолтыг дараах байдлаар тайлбарлажээ: гаднын эсвэл дотоод шинж чанарын нэгдлүүдийг эсвэл элементийг нэмэх; илүү үнэ цэнэтэй нэгдлүүдийг эсвэл элементийг үнэ цэнэ багатай эсвэл идэвхгүй орц найрлагаар орлуулах, тэгсэнээр ХАА-н гаралтай бүтээгдэхүүнтэй хамааралтай онцгой шинж чанар бүхэлдээ болон зарим шинж чанараараа адилхан байх боломжгүй болдог. Эдгээр тохиолдлууд ихэвчлэн амьтны гаралтай бүтээгдэхүүнүүд болох зөгийн бал, шувуу загасны бүтээгдэхүүнүүдэд ихэвчлэн илэрдэг бөгөөд зүйлийг эсвэл орц найрлагыг орлуулан солих (59) гэдэг. Бусад мэдэгдэл нь хоолны дэглэм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, баяжуулсан хүнс зэрэг янз бүрийн барааны зөвшөөрөгдөөгүй/мэдэгдээгүй эмчилгээ, үйл явц, бүтээгдэхүүнтэй (49) холбоотой байв (14).

"Илт худал мэдэгдэл тавих, шошго/баглаа боодолтой дээрх мэдээллийг мушгин гуйвуулах" гэж тодорхойлогддог буруу тодорхойлолт/буруу тэмдэглэгээ/буруу бренд (23.8%) нь луйварын хоёр дахь хамгийн их мэдэгдэл болсон байна. Асуудлууд нь ихэвчлэн чанар, хугацаа дуусах / үйлдвэрлэлтийн огноо, газар зүйн эсвэл шим тэжээл/эрүүл мэндийн талаарх гэх мэтээр төрөл бүрийн асуудлууд орж байсан.

2023 онд саарал зах зээл (жинхэнэ бүтээгдэхүүнийн албан бус сувгаар, жинхэнэ үйлдвэрлэгч, брэндээр дамжуулалгүй зах зээлд нийлүүлдэг) нийт мэдэгдлийн 18.3%-ийг эзэлсэн байна. Энэ төрлийн луйвар нь "зөвшөөрөлгүй борлуулалтын сувгуудтай холбоотой үйлдвэрлэл, хулгай, шилжүүлэх (мөрдөн шалгах асуудал)"-д

багтдаг. Хэд хэдэн хүсэлтэд амьд амьтан (19) эсвэл ургамал хамгаалах бүтээгдэхүүн (9) хууль бусаар оруулсан байна.

Баримт бичгийн хуурамч үйлдлийг (9.5%) "гэрчилгээ, паспорт, шинжилгээний тайлан, хууль журамд нийцэж байгааг баталсан мэдэгдэл болон бусад тодорхойлолт, зэрэг барим бичгүүдийг үйлдэх, өөрчлөх, хуурамчаар тайлбарлах, дуурайлгах үйл явц" гэж тодорхойлдог. Амьд амьтад хамгийн их мэдэгдэлд бүртгэгддэг бүтээгдэхүүний хоёр дахь ангилал учраас хуурамч бичиг баримтын хувьд амьтны паспорт, түүнийг дагалдаж буй тодорхойлолт (6) эсвэл амьтан, ургамлын эрүүл мэндийн гэрчилгээ (9)-г хуурамчаар үйлдсэн мэдэгдлүүд байхаар байна.

Эцэст нь хамгийн бага мэдэгдэлд бүртгэгдсэн луйварын ангилалд (7.8%) хуурамч бүтээгдэхүүнүүд орж байгаа бөгөөд хуурамч бүтээгдэхүүнийг тодорхойлохдоо "эдийн засгийн давуу байдал олж авах зорилгоор оюуны өмчийн эрх (IPR), түүний дотор хөдөө аж ахуйн жинхэнэ бүтээгдэхүүн эсвэл баглаа боодлыг дууриалган олшруулах, жишээлбэл брэнд нэр, сав баглаа боодлын зарчим, боловсруулалтыг аргыг хуулбарлах үйл явц" гэж тодорхойлдог. Эдгээр мэдэгдлүүдийн ихэнх нь сүү, сүүн бүтээгдэхүүн (14) төрлийн бүтээгдэхүүний ангилалд харьяалагддаг Хамгаалагдсан гарал үүсэл (PDO), хамгаалагдсан газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүн (PGI) тухайлбал фета эсвэл халлуми бяслагтай холбоотой зөрчлүүд бүртгэгддэг.

- **Ургамал хамгааллын бүтээгдэхүүнүүд**

2023 оны 5-р сард Европын Комиссын Эрүүл мэнд, Хүнсний аюулгүй байдлын Ерөнхий Захирлын газраас хууль бус ургамал хамгааллын бүтээгдэхүүний талаар авах арга хэмжээг эхэлсэн бөгөөд 2024 оны Дөрөвдүгээр сар хүртэл үргэлжлэх болно. Энэхүү үйл ажиллагаа нь EU Agri-Food Fraud Network (ЕХ-ны Хөдөө аж ахуй – Хууль бус хүнсийг бүртгэх сүлжээ) болон ургамлын эрүүл ахуйн бүтээгдэхүүнийг EMPACT Envicrime дэд үйл ажиллагаа, Оюуны өмчийн эрхтэй холбоотой тохиолдлуудыг Silver Axe үйл ажиллагааны хүрээнд Европтой нягт хамтран хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээ анх удаа нэгэн зэрэг мэргэжлийн болон хууль сахиулах хүчний гурван байгууллагуудын зүгээс нь хууль бус пестицидийн наймааг чиглэсэн арга хэмжээ болсон. Оролцогчдын уялдаа холбоо, эрх бүхий байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, нууц мэдээллийг түгээх нь заримдаа бэрхшээлтэй ч гэсэн арга хэмжээг амжилттай явуулах гол түлхүүр нь болж чадсан.

3.4. Хууль бус хуурамч хүнс, хүнсний луйврын талаар ААС болон RASFT (Хүнс тэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх систем) сүлжээнд


ЕХ нь iRASFF-д бүртгэгдсэн хүнсний үл тохирлууд, зөрчил, хууль бус хүнсний луйвар болон RASFF-тэй холбоотой бүх мэдэгдлүүдийг долоо хоног бүр шалгаж, ЕХ-ны хөдөө аж ахуйн хүнсний сүлжээний хууль тогтоомжийг санаатайгаар зөрчсөн байж болзошгүйг илрүүлж, эсвэл уг хэргийг ЕХ-ны түвшинд зохицуулж, хяналт тавих шаардлагатай бол шалгадаг. Эдгээр зөрчлүүдийн талаар эрх бүхий байгууллагуудад анхааруулан хүргүүлж дараа нь тодруулга мэдээлэл өгөх эсвэл шаардлагатай мөрдлөгийг явуулахыг шаарддаг. 2023 онд мэдээллийг тогтмол шалгаснаар ЕХ хууль бус сэжигтэй 1075 тохиолдлыг ААС болон 1625 тохиолдлыг RASFF-ийн мэдэгдлүүдээс илрүүлсэн. 2022 онтой харьцуулахад энэ тоо нь ААС-ийн сүлжээнд 100%, RASFF-ийн 40%-аар тус тус нэмэгдсэн байна.

3.4.1 Хууль бус, хуурамч хүнсний сэжиг бүхий тохиолдлуудыг тоогоор илэрхийлбэл


2021, 2022 онуудтай адилхан 2023 онд ЕХ-ны орнуудад зөвшөөрөгдөөгүй пестицид хэрэглэсэн үл тохирлууд (434 мэдэгдэл), RASFF буюу Хүнсний аюулгүй байдал, тэжээлийн сүлжээнд бүртгэгдсэн (761 мэдэгдэл) зөрчлүүд хамгийн их бүртгэгдсэн тохиолдол байлаа. Chlorpyrifos хамгийн их бүртгэгдсэн пестицид (282 мэдэгдэл) байсан. Арван тохиолдлын есөд нь, эдгээр зөрчил илэрч буй бараанууд ЕХ-ны гишүүн бус орнуудаас ирсэн бөгөөд хууль тогтоомжийн хувьд өөр буюу хэрэглэхийг зөвшөөрдөг байж болох юм. Европын холбоонд эдгээр бодисын

хэрэглээг зөвшөөрдөггүй бөгөөд энэ нь ямар нэг хууль бус үйлдлүүд явагдаж буйг илэрхийлсэн дохио байж болох юм.

Зураг 12: ААС-ийн сүлжээнд бүртгэгдсэн сэжигтэй, хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүнийг зөрчлийн шинжээр нь ангилан харуулбал (пестицидээс бусад)




Зураг 13: RASFF (Европын холбооны Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх систем)-ийн сүлжээнд бүртгэгдсэн сэжигтэй, хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүнийг зөрчлийн шинжээр нь ангилан харуулбал (пестицидээс бусад)



2023 оны хугацаанд хоолны дэглэмийн бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, баяжуулсан хүнсний бүтээгдэхүүн дээр 441 тохиолдолд (140 AAC, 301 RASFF мэдэгдэл) луйврын сэжиг илрүүлсэн байна. Тиймээс сүүлчийнх нь жимс, хүнсний ногооны дараа (804 тохиолдол) хамгийн их мэдэгдсэн бүтээгдэхүүний ангилалд хоёрдугаар байр эзэлжээ. Энэ ангилалд бүтээгдэхүүн нь зөвшөөрөгдөөгүй шинэ хүнс хэрэглэх (195 тохиолдол, үүнээс 97 нь каннабиноидтай холбоотой), зөвшөөрөлгүй үйл явц, эмчилгээ, бүтээгдэхүүн (89 тохиолдол), хоол тэжээл, эрүүл мэндийн талаарх зөвшөөрөлгүй мэдэгдэл (76 тохиолдол) гэсэн гурван гол луйврын шинжтэй зөрчилд өртөмтгий байдаг. Үүний зэрэгцээ зөвшөөрөлгүй шинэ хүнсний талаарх мэдэгдлийн гуравны хоёр нь хоолны дэглэмийн бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, баяжуулсан хүнсэнд хамаардаг.

Зураг 14: AAC болон RASFF-ийн мэдэгдлүүдийг бүтээгдэхүүнээр ангилан харуулбал



3.4.2. Сэжиг бүхий хуурамч хүнс, хүнсний луйврын талаар Европын Холбоо (ЕХ)-ны бус орнуудтай явуулж буй харилцаа холбоо

Хуурамч хүнсний сэжигтэй тохиолдлууд (RASFF, AAC) 70%-иар нэмэгдсэн байгаа нь ЕХ-руу гаднаас ирж буй бүтээгдэхүүнүүдтэй холбоотой байна. Тийм учраас ЕХ-ны зүгээс ЕХ-ны гишүүн бус орнуудтай байнга холбоо тогтоож мэдээллийг хүргүүлэн ЕХ-д борлуулдаг ижил төстэй бүтээгдэхүүнийг олж тогтоох, хөдөө аж ахуйн хүнсний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд хүнсний бүтээгдэхүүний хуурамч үйлдвэрлэл явуулах, хууран мэхлэх үйлдлээс урьдчилан сэргийлэх, мөрдлөг явуулах, хянах арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлж байхыг эрх бүхий байгууллагуудаас хүсч ажилладаг. Энэ нь ийм төрлийн луйврын хууль бус ажиллагаатай тэмцэх хил хязгаарын хамтын ажиллагаанд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

2021 он хүртэл ЕХ эдгээр асуудлаар ЕХ-ийн гишүүн бус орнуудтай харилцахдаа зөвхөн албан ёсны захидлыг солилцоход тулгуурладаг байсан бол 2022 он харилцааны шинэ арга барилын эхлэл болсон юм. iRASFF нь мэдээллийг эрх мэдэлтнүүдтэй шууд хуваалцах боломжийг олгодог бөгөөд энэ нь илүү үр дүнтэй, тогтвортой харилцааг бий болгож байна.

3.5. Бусад ACN сүлжээний асуудлууд

3.5.3. Загас, загасан бүтээгдэхүүнүүд

2023 онд загас, cephalopods, хавч хэлбэртэн, моллюск (болон бусад хамааралтай бүтээгдэхүүнүүдтэй) зэрэг бүтээгдэхүүнүүдтэй холбоотой 777 тохиолдол (541 RASFF, 204 AAC болон 32 FF мэдэгдэл) -ын мэдэгдэл үүссэн. Эндээс харахад 2023 онд хүлээн авсан мэдэгдлийн нийт тоо 2022 оныхтой харьцуулахад 22.5%-аар өссөн байна. Хамгийн их мэдэгдэл гаргасан орнуудад Испани (23%), Итали (19%), Герман (13%), Бельги (7.3%), Нидерланд (6.9%) орж байна.

Эдгээр бүтээгдэхүүний гарал үүслийг харвал Испани (13.1%), Франц (10%), Нидерланд (7.6%), Эквадор (6.9%), Итали (5.3%) улсууд байна.

Долоо хоног бүрийн сүлжээний шалгалтаас харахад энэ бүлэгт хамаарах нийт 144 мэдэгдлүүд нь хууль бус ангилалд хамаарч байгааг онцолсон. Энэ ангиллын зөрчлийн 52.7% нь зөвшөөрөлгүй нэмэлт бүтээгдэхүүнийг хэрэглэсэн буюу бүтээгдэхүүний гадаад төрх, шинж чанарыг өөрчилсөн байна. 27% нь саарал зах зээлийн буюу хуурамч, хууль бус худалдаа/эсвэл зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдээр дамжсан байх магадлалтай тохиолдлууд гэж үзсэн. 14.6% нь шошго дээрхи мэдээлэл буруу буюу үндсэндээ шошго хаяганд бичигдээгүй нэмэлтүүд болон нөөшлөгчидтэй холбоотой хэргүүд байна. Хамгийн сүүлд 5.6% нь баримт бичгийг хуурамчаар үйлдсэн гэж ангилалд хамаарах бөгөөд худалдааны буюу мөрдөн шалгах баримт бичиг байхгүй эсвэл буруу байсан.

2023 онд гишүүн орнуудын хувьд энэ чиглэлээр илүү анхаарал хандуулж эхэлсэн бөгөөд ЕХ-ны зүгээс загас, загасан бүтээгдэхүүний жин дутагдалтыг тогтоох ЕХ-ны хамтарсан төлөвлөгөөт ажлыг эхлүүлжээ. Загасан бүтээгдэхүүний жин дутах гэдэг нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жинд янз бүрийн аргаар жингийн хэмжээг нэмж, бүтээгдэхүүний хэмжээг буруугаар тооцох тохиолдолдлуудыг хэлдэг.

Төлөвлөгөөт үйл ажиллагаа нь зориудаар ус нэмэх, тусгай нэмэлтүүдийн усыг бүтээгдэхүүнтэй барьцалдуулах журмаар хэрэглэх, эсвэл үржлийн аргыг хэрэглэх зэрэг хууль бус үйлдлүүдийг олж илрүүлэхэд төвлөрсөн. 2019 оноос хойш нийт 196 мэдэгдлээр 239 залилан мэхлэх үйл ажиллагаа бүртгэгдсэн байна. Мэдэгдлүүдийн талаас илүү нь бараа бүтээгдэхүүнд нууцаар ус нэмэхтэй холбоотой зөрчлүүд байсан.

Мэдэгдлийн 32% нь хэрэглэгчийг төөрөгдөлд оруулсан, бараа бүтээгдэхүүний жинг мэдэгдэлгүйгээр өнгөлөгчтэй (undeclared glazing) хамт тооцсон байв. Зарим мэдэгдэлд (7%) зөвшөөрөлгүй нэмэлтүүдийг жишээлбэл карбонатыг хэрэглэсэн бол 4% нь зөвшөөрөгдсөн нэмэлт бодисыг хэрэглэсэн боловч хаяг шошго дээр тэмдэглээгүй байсан. Зураг 18-д бүтээгдэхүүн илэрч буй луйврын төрлөөр нь ангилан харуулж байна.

Зураг 18: AAC болон RASFF-ийн мэдэгдлүүдийг бүтээгдэхүүнд илэрч буй луйврын төрлөөр нь ангилбал:



3.6. Ургамлын эрүүл мэнд


2023 онд Ургамлын эрүүл мэндийн мэдэгдлийн солилцсон тоо нийт 128-д хүрсэн. Ургамлын эрүүл мэндийн сүлжээнд 20 улс мэдэгдэл оруулсан бөгөөд хамгийн их тоог Бельги, Испани (19), дараа нь Франц (18), Чех (13) улсууд оржээ.

Хамгийн их бүртгэгдсэн 56 мэдэгдлийг зах зээлд албан ёсны хяналт шалгалтыг хийх явцын үеэр гаргасан ба үүнээс хүнсний үйл ажиллагаа эрхлэгчдийн байгууламжинд хийсэн албан ёсны хяналтын үед 42 мэдэгдэл, үүнээс үүдэлтэй дараагийн хяналтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болон хяналтын дээжүүдийг авах үед 5 мэдэгдэл үүсгэжээ.

128 мэдэгдлээс 113 нь зөрчлийн талаар мэдээлсэн бол 11 нь гэнэтийн төлөвлөгөөтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэж, 4 нь луйвар болон бусад асуудалтай холбоотой хэргүүдтэй холбоотой байсан. Зөрчлийн мэдэгдлүүдээс харахад 75 нь ачаа бараанд зохицуулагдах ангилалд хамаарах ургамлын хортон байгааг мэдэгдсэн. Хортонгуудад шавьж, вирус, цагираг хорхой, мөөгөнцөр, бактери орно. Эдгээр ургамлын хортонгууд нь таримлын ургацыг бууруулж, ургамлын ногоон массд өнгө хувиргалтыг үүсгэж ургамлыг ялзруулан муутгаж, үхэлд хүргэх зэрэг олон төрлийн хор хөнөөл учруулдаг. 24 мэдэгдэлд ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ (ачаа барааг баталгаажуулсан баримт бичиг бөгөөд барааны өмчлөгчийн талаарх мэдээлэл, ямар орноос гарал үүсэлтэй, тандан мөшгих код зэргийг тусгасан байдаг) хууль ёсны бус байсан байна.

Түүнээс гадна, 14 мэдэгдэлд модон баглаа боодлын материал (тээвэрлэлтийн үед зарим бараа бүтээгдэхүүнийг хайрцаглаж, хүрээлж, бэхлэдэг мод) дээр Олон улсын ургамал хамгааллын стандартын (ISPM, International Standards for Phytosanitary Measures) тэмдэг байхгүй байсныг бүртгэн оруулжээ. ЕХ-ны гишүүн бус орнууд болон Португалиас ирсэн модон баглаа боодлын материал нь ЕХ-ийн нийтийн зах зээлд анх орж ирэх болон зах зээлд хэрэглэгдэж байхад зориулж "ISPM 15" гэсэн тусгай тэмдэг, улсын код, модон материалыг ариутгалын үйлчилгээ үзүүлэгчийн код, ариутгалын кодыг тэмдэглэсэн тусгай тэмдэгтэй байх ёстой.

Зураг 19: Зөрчлийн мэдэгдлийн тоог зөрчлийн ангиллаар нь харуулбал



Мэдэгдэлд хамрагдах бараа бүтээгдэхүүнийг гарал үүслээр нь авч үзэхэд 102 мэдэгдэл нь ЕХ-ийн дотроос ирсэн бараа бүтээгдэхүүн, үүнээс 20 нь Нидерландын гарал үүсэлтэй гэж мэдээлсэн бол Итали 19, дараа нь Испани 18 мэдэгдэлтэй байна. 15 мэдэгдлүүд нь ЕХ-оос өөр орноос ирсэн бараа бүтээгдэхүүнд хамааралтай байна. Хамгийн их буюу 21 мэдэгдэлд нарс мод (*Pinus sp.*)-ны зүйл орсон байлаа. Үүнээс 14 нь "ISPM 15" тэмдэглэгээгүй модон баглаа боодлын материал, 6-д нь хортон шавьж илрүүлсэн тухай бүртгэсэн, 1 нь ургамлын гэрчилгээгүй байсан. Төмсний (*Solanum tuberosum*) 12 мэдэгдэл байснаас 11 нь үржүүлгийн төмснөөс өөр төмсний булцуу болох мэдэгдэл 1 нь төмсний хаягдалтай хөрсний мэдэгдэл тус тус байсан.

Нэмээд 11 мэдэгдэл улаан лоолийн (*Solanum lycopersicum*), үр, ургамал, навч, жимстэй холбоотой байсан бол инжрийн ургамал (*Ficus carica*) дээр 9 мэдэгдэлтэй байна. Ургамлын төрөл зүйл маш их өргөн цар хүрээтэй байдаг боловч тэдгээр дээр гарч буй мэдэгдлүүдийн тоо харьцангуй цөөхөн учраас ихэнхи бараан дээр нэгээс хоёр л мэдэгдлүүд жил бүр бүртгэгддэг байна.

Инно Хими Лаб ХХК – ийн танилцуулга:

Үйлчилгээний нэр төрөл:

- Хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээний лабораторийн шинжилгээ
- Химийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, урвалжийн худалдаа
- Химийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ
- Химич, химийн мэргэжилтний сургалт, зөвлөгөө


Бүтээгдэхүүний нэр төрөл:

- Тоног төхөөрөмж
- Багаж хэрэгсэл
- Урвалж, уусмал
- Стандарт бодис, оношлуур
- Химийн бодис
- Шил сав, дагалдах хэрэгсэл

- Пестицидийн үлдэгдэл
- Өвчин үүсгэгч бичил организмын бохирдол
- Мөөгөнцрийн бохирдол
- Хуурамч хүнс
- Тусгай хүнс
- Харшил үүсгэгч
- Найрлага
- Гадны биетийн бохирдол
- Хүнсний нэмэлт

Хэрэглэгчидийнхээ цаг завьг хэмнэх, тасралтгүй ажиллагааг дэмжих үүднээс

www.innochem.mn онлайн худалдааны сайтыг нэвтрүүлээд байна.



Инно лаборатори

- Химийн лабораторийн мэргэжилтнүүдэд өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах орчин бүрдүүлэх, чадамжийг сайжруулах
- Хүнсний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад лабораторийн шинжилгээг олон улсын стандартын дагуу нэвтрүүлж хувь нэмрээ оруулах

Шинжилгээний хүрээ:

- Пестицидийн үлдэгдлийн шинжилгээ
- Усанд болон тосонд уусдаг витамины шинжилгээ
- Хүрээлэн буй орчны бохирдлын шинжилгээ